

“Си И Си Инвесмент ББСБ” ХХК



ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү баримт бичгээр “Си И Си Инвестмент ББСБ” ХХК /цаашид “Компани” гэх/-ийн цалин, урамшууллын үндсэн зарчим, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлно.
- 1.2 Компанийн үйл ажиллагааны чиглэл, онцлогт тохируулан зах зээлд өрсөлдөхүйц хэмжээтэй цалин, урамшууллыг тогтоох зарчмыг баримтална.

ХОЁР.ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- 2.1 Цалин, урамшууллын талаар компанийн хэмжээнд баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 2.1.1 Ижил үнэлэмж бүхий хөдөлмөрт адил цалин, урамшуулал олгох,
 - 2.1.2 Цалин, урамшууллын жишиг тогтоох, хуваарилалтад аливаа ялгаварлал, гадуурхал, тэгш бус байдлыг гаргахгүй байх,
 - 2.1.3 Цалин, урамшууллыг мэдлэг, ур чадвар, туршлага болон ажлын үнэлгээ, гүйцэтгэл, үр дүнд суурилж тогтоох,
 - 2.1.4 Хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн өсөлтийн зохистой харьцаа болон инфляцын түвшинтэй уялдуулж бодит цалингийн өсөлтийг хангах,
 - 2.1.5 Монгол улсын нэгдэн орсон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, Зохистой хөдөлмөрийн үзэл баримтлалын дагуу ажилтнуудын цалин, урамшууллыг шударга хуваарилах, хөдөлмөрчдийн эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээр болон хамтын гэрээ байгуулах эрхийг хүлээн зөвшөөрөх
- 2.2 ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо /цаашид “Хороо” гэх/ нь эрх бүхий албан тушаалтан болон ажилтнуудад олгох цалин, урамшууллын дээд, доод хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах, холбогдох хууль тогтоомж болон ТУЗ-өөс тодорхойлсон бусад асуудлын хүрээнд дараах хэлбэрээр, зохистой хэмжээг тогтоон олгоно. Үүнд:
 - 2.2.1 Компанийн цалингийн сүлжээг батлуулна.
 - 2.2.2 Компанийн үйл ажиллагааны чиглэл болон бусад нөхцөл байдлаас шалтгаалсан бусад хэлбэрийн мөнгөн болон мөнгөн бус урамшуулал
- 2.3 Хороо нь эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих, холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргана.
- 2.4 Хороо нь компанийн ажилтнуудын цалин, урамшуулалтай холбоотой дотоод дүрэм, журам, системийн үр дүнг үнэлж, холбогдох хууль тогтоомжид нийцэж буй байдалд хяналт тавих, компанийн цалингийн бодлого, түвшин, сүлжээ, цалин тогтоох журамд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг ТУЗ-д тайлагнаж, ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлнэ.
- 2.5 ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарна.

“Си И Си Инвесмент ББСБ” ХХК



Төлөөлөн удирдах зөвлөлийн
Чалин, урамшууллын хорооны
2023 оны _____-р сарын _____ ны өдрийн
_____ тогтоолын Хавсралт

2.6 Энэхүү бодлогыг баримт бичгийн хэрэгжилт, боловсронгуй болгох ажлыг тухай бүр хийнэ.

ГУРАВ.ХЯНАЛТ

3.1 Энэ бодлогын хэрэгжилтэд Хороо хяналт тавьж ажиллах ба ТУЗ-өөс энэхүү бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.